



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/568

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Хот байгуулалтын тухай хуулийн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны ээлжит бус IV хуралдааны 01 дүгээр тогтоол, 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит XXVI хуралдааны 22 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ мөрөн хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлыг үргэлжлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн дүгнэлт, аймгийн Засаг даргын Тамгын газрын хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/464 дүгээр захирамжаар Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар (РД:9070354)-т эзэмшүүлсэн Мөрөн сумын 1 дүгээр баг, Стадионы ар талд байршилтай 6712017706 нэгж талбарын дугаар бүхий төрийн байгууллагын зориулалттай 46422 м² газрыг “Стресс сэвэрс” ХХК (РД:6306632)-д шилжүүлэн үлдсэн 29 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/464 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.


3. Захирамжаар газар эзэмшигч хуулийн этгээд “Стресс сэвэрс” ХХК (РД:6306632)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хой 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Р.Машбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ